



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-Д БҮРТГЭЛТЭЙ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД 2023 оны эхний хагас жил

Гүйцэтгэсэн:

А.Авир, Дарга
Л.Мөнхзаяа, Ахлах референт
Ж.Лхагвамядаг, Мэргэжилтэн

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-Д БҮРТГЭЛТЭЙ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

(2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар)

1. ҮЙЛ ЯВЦЫН ӨРНӨЛ

2006 он

Монгол Улсын Их хурлаас “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийг баталж, компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох бүрэн эрхийг тус Хороонд олгов.

2007 он

“Монгол компанийн засаглалын кодекс”-ийг Хороо анх удаа батлав.

2014 он

“Компанийн засаглалын кодекс”-т нэмэлт, өөрчлөлт оров.

2022.3.23

Хорооны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийн шинэчилсэн найруулга батлагдлаа. Шинэчилсэн кодексийн хавсралтаар олон улсад түгээмэл ашиглагддаг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмаар үнэлгээний аргачлал бүхий тайлангийн маягт болон компанийн дотооддоо баталж, мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журмын зааврын үлгэрчилсэн загваруудыг батлав.

2022.4.15

Кодекс “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл”-д бүртгэгдэж, эрх зүйн мэдээллийн www.legalinfo.mn нэгдсэн системд байршсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба нээлттэй хувьцаат компани, даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд дагаж мөрдөх үүргийг хүлээв.

2022.6.22

Хорооны даргын 2022 оны 336 дугаар тушаалаар “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийг баталж, компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх нэгдсэн зохион байгуулалт, зах зээлд оролцогч талуудын баримтлах зарчим, чиг үүргийг тодорхойлов.

2022.11.03

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 1 болон 2 дугаар ангилалд бүртгэлтэй нийт 66 ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагыг оролцуулан кодексийн хэрэгжилтийн үнэлгээг хэрхэн тайлагнах сэдвээр нийтдээ 6 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

2022.12.30

Хорооны зохицуулалтын 3 салбарын нийт 116 зохицуулалттай этгээд /даатгагч, хөрөнгө оруулалтын менежментийн компани, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк санхүүгийн байгууллага/-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэн тайлангийн хариугаар заавар зөвлөмж, эсхүл хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь тооцон салбар тус бүрийн зэрэглэлийг тогтоож, нийтэд мэдээлэв. Үнэлгээг хянан баталгаажуулахад, 2022 оны 8 дугаар сарын байдлаар кодексийн хэрэгжилтийн анхны буюу нөхцөл байдлын үнэлгээ 55.3 хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрт зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, мөн оны 12 дугаар сард биелэлтийг нь тооцсон давтан үнэлгээгээр зохицуулалттай 3 салбарын кодексийн хэрэгжилт дунджаар 16.4 хувиар өсөв.

2023.01.02

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын кодексийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг эхлүүлэв.

2023.03.01

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 1, 2 дугаар ангиллын 68 ХК, 3 дугаар ангилалд бүртгэлтэй 39 ХК, нийт 108 ХК-ийн кодексийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч, хянан баталгаажуулан тайлан тус бүрийн хариугаар хугацаатай үүрэг, даалгавар өгөгдөв.

2023.06.30

Кодексийн анхдагч үнэлгээний хариугаар Хороонд ирүүлсэн нийт 47* үнэт цаас гаргагчийн тайланг давтан үнэлж, ахиц дэвшлийг тогтооход кодексийн хэрэгжилт дунджаар 12.7 хувиар өсчээ. Ингэснээр компанийн засаглалын чанар буюу кодексийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд суурилсан зэрэглэл тогтоож эхлэв. Кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж, нэгдсэн тайлан гаргаж, зэрэглэл тогтоосноор компанийн засаглалын өнөөгийн нөхцөл байдал, эрсдэл, чиг хандлагыг тодорхойлон зохицуулалтын орчныг оновчтой болгох, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад нь шаардлагатай чанарын үзүүлэлтүүд бий болов.

2024 он

“Компанийн засаглалын үндэсний индекс”-ийг тооцож эхэлнэ. Үнэт цаасны арилжаа эрхлэгч байгууллагад бүртгэлтэй нийт үнэт цаас гаргагчдын компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч 10 хувьцаат компаниудаар үндэсний индексийн сагсыг бүрдүүлснээр “Компанийн засаглал үр дүнтэй байх нь хувьцаат компанийн зах зээлийн үнэлгээнд нөлөөлдөг эсэх?” асуулгын хариултыг хөрөнгө оруулагчдад өгч чадах тоон өгөгдлийг бий болгоно.

Кодексийн хэрэгжилтийн үнэлгээ, компанийн засаглалын зэрэглэл, үндэсний индекст үндэслэн жил бүрийн тайланг боловсруулж, үнэт цаасны зах зээлд оролцогчдын дунд нээлттэй хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулан компанийн засаглалын зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулна.

* 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар “Газар шим үйлдвэр” ХК, “Хаан банк” ХК, “Худалдаа хөгжлийн банк” ХК, “Хас банк” ХК нь Хөрөнгийн биржид хараахан бүртгэгдээгүй байсантай холбогдуулан эдгээр үнэт цаас гаргагчдын кодексийн хэрэгжилтийн зөвхөн анхдагч тайлан хянан баталгаажуулагдсан ба давтан үнэлгээ хийгдээгүй тул ахиц дэвшлийг тогтоогоогүй болно.

2. СУДАЛГААНЫ ТАЛААР

Компанийн засаглалыг нэвтрүүлэх нь бизнесийн үйл ажиллагааны урт хугацааны өгөөжийг хангах төдийгүй хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд суурилсан шударга, нээлттэй зах зээлийн орчин бүрдэхэд эерэгээр нөлөөлдөг тул нийгэмд ач холбогдолтой энэ сэдвийг онцгойлон анхаарч, тогтмол хөгжүүлэх шаардлагатай.

Олон улсын практикын дагуу компанийн засаглалын чанар, кодексийн хэрэгжилтийг үнэлэхдээ эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн зэрэглэл тогтоох аргыг ашиглав.

Компанийн засаглалын зэрэглэл нь тухайн компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн дүн шинжилгээ хийх мэдээлэл болж өгснөөр хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрсдэлгүй шийдвэр гаргалтад эерэгээр нөлөөлнө.

3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

- Кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж нэгдсэн тайлан боловсруулах;
- компанийн засаглалын хандлага, учирч болох эрсдэлийг тодорхойлох;
- хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч эрсдэлийн үнэлгээ хийж, шийдвэр гаргах засаглалын үзүүлэлтийг бий болгох;
 - үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн ангилал бүрээр засаглалаар тэргүүлэгчдийг тодруулах, компанийн засаглалын зэрэглэл тогтоох;
 - нээлттэй хувьцаат компаниудад өөрийн засаглалыг харьцуулах, сайжруулахад чиг баримжаа болох компанийн засаглалын жишгийг тодорхойлох;
 - хууль тогтоомж болон хувьцаат компанийн баталсан дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журмын эрх зүйн орчныг оновчтой болгож, сайжруулах;
 - хугацааны цуваа хэлбэрээр статистик мэдээллийг үүсгэх.

4. АРГАЧЛАЛ

Судалгаа нь “Компанийн засаглалын кодекс”-ийн 36 зүйлийн хэрэгжилтийн асуумжаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй 108 ХК-ийн анхны үнэлгээ, 47 ХК-ийн давтан үнэлгээний тайлангууд болон Хорооноос хэрэгжүүлсэн судалгааны үр дүнд суурилсан.

4.1. Судалгааны голлох сэдэв:

а. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагаа, бүтэц, бүрэлдэхүүн.

б. Дотоод эрх зүйн зохицуулалын ил тод байдал /Цахим хуудасны шинэчлэл/:

- бодлогын баримт бичиг;
- ёс зүйн дүрэм;
- компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны журам;
- мэдээллийн ил тод байдал, тайлагнал, комплайнсын хяналт, эрсдэлийн удирдлагын журам, заавар;
- компанийн эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр.

в. Хамгийн сайн болон муу хэрэгжсэн засаглалын үзүүлэлтүүд.

4.2. Судалгаанд хамрагдагсад:

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниуд:

а. Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс нийт 108 хувьцаат компанид анхны үнэлгээг хийж, тайлангийн хариугаар хугацаатай үүрэг бүхий албан тоот хүргүүлснээр нийт 47 компанийн давтан зайны үнэлгээг кодексийн хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлэв.

б. Компаниудын ирүүлсэн зайны үнэлгээг хавсаргасан нотлох баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцов.


в. Үнэлгээний нэгдсэн дүнг үндэслэн компани тус бүрт тухайлсан зөвлөмж, чиглэл хүргүүлэн тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлов.

Компанийн үнэлгээний нэгдсэн дүн нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэл хийхтэй холбоотойгоор Хорооноос холбогдох шийдвэр гаргах, компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй, оновчтой болгох чиглэлд дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын зэрэглэлийн нэгдсэн судалгааг гарган нийтлэх, мэдээллийн зорилгоор ашиглагдана.

5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

5.1. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээнд суурилан хугацаатай чиглэл, үүргийг хүргүүлснээр гарсан ахиц дэвшил:

Дурслал 1




Шигтгээ 1: Давтан үнэлгээгээр нийт 47 ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 12.7 хувиар өсөв.

Шигтгээ 2: Хөрөнгийн биржийн 1 дүгээр ангилалд бүртгэлтэй компаниуд 18.4, 2 дугаар ангилал 14.9, 3 дугаар ангиллын үзүүлэлт 4.8 хувиар тус тус өсөлтийг харуулав.


5.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ болон биржийн бүртгэлийн ангиллын харилцан хамаарал:

Дүрслэл 2



5.3. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ болон Зах зээлийн үнэлгээний харилцан хамаарал:


Дүрслэл 3



Дүрслэл 4



Дүрслэл 5



Дүрслэл 6



Шигтгээ 3: “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн болон Зах зээлийн үнэлгээ, бүртгэлийн ангиллын хооронд харилцан хамаарал ажиглагдав.

5.4. Цахим хуудсандаа ил болгосон мэдээлэл:


Дүрслэл 7



6. МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН 1 ДҮГЭЭР АНГИЛАЛД БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД

6.1. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлангийн ахиц дэвшил:

Дүрслэл 8



Шигтгээ 4: Хөрөнгийн биржийн 1 дүгээр ангилалд бүртгэлтэй 16 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 18.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

6.2. ТУЗ-ийн бүрэлдэхүүн:

Дүрслэл 9




Шигтгээ 5: ТУЗ-ийн бүрэлдэхүүн 9-12 гишүүнтэй, үүнээс 44.0% нь хараат бус гишүүд байна.

Шигтгээ 6: Нийт ТУЗ-ийн гишүүдийн 28.0 хувийг эмэгтэй гишүүд эзэлж байна.


6.3. ТУЗ-ийн үйл ажиллагаа:

Дүрслэл 10



6.4. ТУЗ-ийн бүрэлдэхүүний эрх бүхий албан тушаалтнаар ажилласан ажлын туршлага /жилээр/:

Дүрслэл 11




6.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Дүрслэл 12




6.6. ТУЗ-ийн гишүүдийн насжилт ба эзэмшсэн мэргэжил:

Дүрслэл 13



6.7. ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүрийн 2022 онд хуралдсан хурал болон хэлэлцсэн асуудлын тоо /дунджаар/

Дүрслэл 14




Шигтгээ 7: Судалгаанд хамрагдсан компаниудын **30.0%** нь Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны чиг үүргийг давхардуулан хэрэгжүүлдэг.

Шигтгээ 8: ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр дунджаар **3-5** гишүүнтэй.

6.8. Компанийн дотоод зохицуулалтын дүрэм, журмын нээлттэй, ил тод байдал:

Дүрслэл 15: Цахим хуудасны мэдээлэл



Шигтгээ 9: 2023 оны хагас жилийн байдлаар **92.0%** нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулсан.

Шигтгээ 10: Тайлант хугацаанд **56.0%** нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.

6.9. Сайн болон муу хэрэгжсэн кодексийн үзүүлэлтүүд:

Дүрслэл 16

Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:


Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:



7. “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН 2 ДУГААР АНГИЛАЛД БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД

7.1. Кодексийн хэрэгжилтийн тайлангийн ахиц дэвшил:


Дүрслэл 17



Шигтгээ 11: Хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй нийт 25 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 14.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

7.2. ТУЗ-ийн бүрэлдэхүүн:

Дүрслэл 18




Шигтгээ 12: ТУЗ нь 9 хүний бүрэлдэхүүнтэйгээс 38.0% нь хараат бус гишүүд байна.

Шигтгээ 13: ТУЗ-ийн бүрэлдэхүүний 30.3% нь эмэгтэй.


7.3. ТУЗ-ийн үйл ажиллагаа:

Дүрслэл 19



7.4. ТУЗ-ийн бүрэлдэхүүний компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажилласан ажлын туршлага: /жилээр/

Дүрслэл 20




7.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Дүрслэл 21




7.6. ТУЗ-ийн гишүүдийн насжилт ба эзэмшсэн мэргэжил:

Дүрслэл 22



7.7. ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2022 онд хуралдсан хурал болон хэлэлцсэн асуудлын тоо:

Дүрслэл 23



Шигтгээ 14: Дунджаар **33.0** хувь нь Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг.

Шигтгээ 15: ТУЗ-ийн дэргэдэх хороод дунджаар **3-5** гишүүнтэй.

7.8. Компанийн дотоод зохицуулалтын дүрэм, журмын нээлттэй, ил тод байдал:

Дүрслэл 24: Цахим хуудасны мэдээлэл



Шигтгээ 16: 2023 оны хагас жилийн байдлаар 85.0% нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулсан.

Шигтгээ 17: Тайлант хугацаанд 51.0% нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.

7.9. Сайн болон муу хэрэгжсэн кодексийн үзүүлэлтүүд:

Дүрслэл 25

Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:


Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:



8. “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН 3 ДУГААР АНГИЛАЛД БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД

8.1. Кодексийн хэрэгжилтийн тайлангийн ахиц дэвшил:

Дүрслэл 26



Шигтгээ 18: Хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй нийт 6 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 4.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

8.2. ТУЗ-ийн бүрэлдэхүүн:

Дүрслэл 27




Шигтгээ 19: ТУЗ нь 9 гишүүнтэйгээс 38.0% нь хараат бус гишүүд байна.

Шигтгээ 20: ТУЗ-ийн бүрэлдэхүүний 25.9% нь эмэгтэй.


8.3. ТУЗ-ийн үйл ажиллагаа:

Дүрслэл 28



8.4. ТУЗ-ийн бүрэлдэхүүний компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажилласан ажлын туршлага: /жилээр/

Дурслэл 29




8.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Дурслэл 30




8.6. ТУЗ-ийн гишүүдийн насжилт ба эзэмшсэн мэргэжил:

Дурслэл 31



8.7. ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2022 онд хуралдсан хурал болон хэлэлцсэн асуудлын тоо:

Дүрслэл 32




Шигтгээ 21: Дунджаар **40.0** хувь нь Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг.

Шигтгээ 22: ТУЗ-ийн дэргэдэх хороод дунджаар **3-5** гишүүнтэй.

8.8.Компанийн дотоод зохицуулалтын дүрэм, журмын нээлттэй, ил тод байдал:

Дүрслэл 33: Цахим хуудасны мэдээлэл





Шигтгээ 23: 2023 оны хагас жилийн байдлаар **67.0%** нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулсан.

Шигтгээ 24: Тайлант хугацаанд **33.3%** нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.

8.9. Сайн болон муу хэрэгжсэн кодексийн үзүүлэлтүүд:

Дүрслэл 34

Хамгийн сайн хэрэгжсэн компанийн
засаглалын үзүүлэлтүүд:Хамгийн сул хэрэгжсэн компанийн
засаглалын үзүүлэлтүүд:

9. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭГЭЭР ТЭРГҮҮЛЭГЧИД†**9.1. Хөрөнгийн биржийн 1 дүгээр ангилал: ТОП 10**

- | | |
|-----------------------|--------------------------|
| 1. “ГОВЬ” ХК | 6. “МИК ХОЛДИНГ” ХК |
| 2. “ИНВЕСКОР ББСБ” ХК | 7. “ГОЛОМТ БАНК” ХК |
| 3. “ТӨРИЙН БАНК” ХК | 8. “ЛЭНДМН ББСБ” ХК |
| 4. “АПУ” ХК | 9. “БОГД БАНК” ХК |
| 5. “СҮҮ” ХК | 10. “АРД КРЕДИТ ББСБ” ХК |

9.2. Хөрөнгийн биржийн 2 дугаар ангилал: ТОП 10

- | | |
|--|-----------------------------------|
| 1. “СЭНТРАЛ ЭКСПРЕСС БИ ЭС” ХК | 6. “МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХК |
| 2. “СЭНДЛИ” ХК | 7. “ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК |
| 3. “ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН” ХК | 8. “ТЕХНИК ИМПОРТ” ХК |
| 4. “УЛААНБААТАР БҮК” ХК | 9. “Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК |
| 5. “ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ” ХК | 10. “АДУУНЧУЛУУН” ХК |

9.3. Хөрөнгийн биржийн 3 дугаар ангилал: ТОП 5

1. “ЭРЭЭНЦАВ” ХК
2. “ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК
3. “ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК
4. “ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК
5. “ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК

10. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДАВТАН ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ /Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав/

Д/д	Компанийн нэрс	Үнэлгээ	Д/д	Компанийн нэрс	Үнэлгээ
1	"ГОВЬ" ХК	98.6%	55	"МОГОЙН ГОЛ" ХК	47.2%
2	"ИНВЕСКОР ББСБ" ХК	98.6%	56	"ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ" ХК	45.8%
3	"ТӨРИЙН БАНК" ХК	93.1%	57	"ХАРХОРИН" ХК	45.8%
4	"СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС" ХК	93.1%	58	"КРИПТО ҮНДЭСТЭН" ХК	43.1%
5	"СЭНДЛИ ББСБ" ХК	91.7%	59	"ХӨВСГӨЛ" ХК	43.1%
6	"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН" ХК	91.7%	60	"МАХИМПЕКС" ХК	41.7%
7	"АПУ" ХК	90.3%	61	"АЙТҮҮЛС" ХК	41.7%
8	"УЛААНБААТАР БҮК" ХК	90.3%	62	"МОНГОЛ БАЗАЛТ" ХК	41.7%
9	"СҮҮ" ХК	88.9%	63	"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК	41.7%
10	"МИК ХОЛДИНГ" ХК	87.5%	64	"ШАРЫН ГОЛ" ХК	41.7%
11	"ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ" ХК	86.1%	65	"ЖИДАКС" ХК	41.7%
12	"ГОЛОМТ БАНК" ХК	84.7%	66	"ИХ БАРИЛГА" ХК	40.3%
13	"МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО" ХК	84.7%	67	"УВС ХҮНС" ХК	40.3%
14	"ЭРЭЭНЦАВ" ХК	84.7%	68	"ДАРХАН НЭХИЙ" ХК	38.9%
15	"ЛЭНДМН ББСБ" ХК	83.3%	69	"БАГАНУУР" ХК	38.9%
16	"БОГД БАНК" ХК	80.6%	70	"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК	38.9%

† 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар “Газар шим үйлдвэр” ХК, “Хаан банк” ХК, “Худалдаа хөгжлийн банк” ХК, “Хас банк” ХК нь Хөрөнгийн биржид хараахан бүртгэгдээгүй байсантай холбогдуулан эдгээр үнэт цаас гаргагчдын кодексийн хэрэгжилтийн зөвхөн анхдагч тайлан хянан баталгаажуулагдсан ба давтан үнэлгээ хийгдээгүй тул ахиц дэвшлийг тогтоогоогүй болно.

17	"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК	80.6%	71	"ДУЛААНЫ 3-Р ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК	38.9%
18	"АРД КРЕДИТ ББСБ" ХК	79.2%	72	"МОН НАБ" ХК	38.9%
19	"БОДЬ ДААТГАЛ" ХК	77.8%	73	"НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ" ХК	38.9%
20	"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК	77.8%	74	"АРИГ ГАЛ" ХК	34.7%
21	"ТЕХНИК ИМПОРТ" ХК	76.4%	75	"ТАХЬ-КО" ХК	33.3%
22	"Э-ТРАНС ЛОЖИСТИКС" ХК	75.0%	76	"МОНГЕО" ХК	33.3%
23	"АДУУН ЧУЛУУН" ХК	73.6%	77	"ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК	31.9%
24	"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК	73.6%	78	"ГУТАЛ" ХК	30.6%
25	"ХОТ ДЕВЕЛОПМЕНТ" ХК	69.4%	79	"МАТЕРИАЛИМПЭКС" ХК	30.6%
26	"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК	68.1%	80	"МОНГОЛ ШИЛТГЭЭН" ХК	27.8%
27	"МОНГОЛ ШУУДАН" ХК	68.1%	81	"МЕРЕКС" ХК	27.8%
28	"ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП" ХК	68.1%	82	"СОР" ХК	27.8%
29	"БИ ДИ СЕК ҮЦК" ХК	66.7%	83	"БЭРХ УУЛ" ХК	26.4%
30	"ГЕРМЕС ЦЕНТР" ХК	66.7%	84	"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК	26.4%
31	"ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК" ХК	66.7%	85	"ДАРХАН ХҮНС" ХК	26.4%
32	"ТАЛХ ЧИХЭР" ХК	65.3%	86	"ХИШИГ УУЛ" ХК	26.4%
33	"ТҮМЭН ШУВУУТ" ХК	65.3%	87	"ШИНЭСТ" ХК	26.4%
34	"БУЛИГААР" ХК	65.3%	88	"ТАВАН ТОЛГОЙ" ХК	25.0%
35	"ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ" ХК	63.9%	89	"БАЯН ТЭЭГ" ХК	25.0%
36	"ХАСУ-МАНДАЛ" ХК	63.9%	90	"ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-4" ТӨХК	25.0%
37	"БАГАНУУР, ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК	62.5%	91	"ГАН ХИЙЦ" ХК	23.6%
38	"МОНОС ХҮНС" ХК	61.1%	92	"ДОРНОД ХУДАЛДАА" ХК	23.6%
39	"МОНГОЛ ДААТГАЛ" ХК	59.7%	93	"БҮТЭЭЛЧ ҮЙЛС" ХК	23.6%
40	"АРД ДААТГАЛ" ХК	58.3%	94	"НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК	23.6%
41	"МОНИНЖБАР" ХК	56.9%	95	"ХОРИН ХОЁРДУГААР БААЗ" ХК	23.6%
42	"МОНГОЛ НЭХМЭЛ" ХК	55.6%	96	"АТАР-ӨРГӨӨ" ХК	22.2%
43	"УЛААНБААТАР ХИВС" ХК	55.6%	97	"НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ" ХК	22.2%
44	"ШИВЭЭ ОВОО" ХК	55.6%	98	"ЛЮКС ЗАНАДУ ГРУПП" ХК	22.2%
45	"МАНДАЛ ДААТГАЛ" ХК	54.2%	99	"ӨНДӨРХААН" ХК	22.2%
46	"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК	54.2%	100	"СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП" ХК	22.2%
47	"БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХК	54.2%	101	"БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ" ХК	20.8%
48	"СИЛК НЭТ" ХК	52.8%	102	"ЭРЧИМ БАЯН-ӨЛГИЙ" ХК	20.8%
49	"ХАЙ БИ ОЙЛ" ХК	51.4%	103	"АЗЫК" ХК	20.8%
50	"АЛТАЙН ЗАМ" ХК	51.4%	104	"СИЛИКАТ" ХК	20.8%
51	"МОНГОЛ САВХИ" ХК	50.0%	105	"ЭМ ЭН ДИ" ХК	20.8%
52	"РЕМИКОН" ХК	50.0%	106	"ЖЕНКО ТУР БЮРО" ХК	16.7%
53	"МОНГОЛ АЛТ" ХК	48.6%	107	"ДЭВШИЛ МАНДАЛ" ХК	16.7%
54	"ТЭЭВЭР ДАРХАН" ХК	48.6%	108	"ХӨВСГӨЛ УСАН ЗАМ" ХК [‡]	70.8%

-oOo-

[‡] "Хөвсгөл усан зам" ХК 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасагдсан.